



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар A/34

Хэрлэн сум

Албан хаагчдын ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтын 5.3.4 дэх заалтад өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Баярцолмон)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА



Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2023 оныдугаар сарын-ны
.....дугаар тушаалын хавсралт



№	2021 оны А/19 дугаартай тушаалаар баталсан өмнөх заалт	Шинэчилэн оруулж буй өөрчлөлт
1.	5.3.4. Тухайн байгууллагад ажилласажил болон ажлын амжилтыг харгалзан жил бүр 3 албан хаагчид орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж тус бүр 10 хүртэлх сая төгрөг олгох	5.3.4. Тухайн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, цаашид 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах, сахилгын шийтгэлгүй албан хаагчид амьдрах орчноо сайжруулах зорилгоор өргөдлийг нотлох баримтын хамт гаргана. Ирсэн өргөдлийг хамт олны хурлаар хэлэлцүүлж, олонхын санал авсан албан хаагчдад тухайн жилд батлагдсан төсөвт багтаж санхүүгийн дэмжлэг олгоно.